



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН  
ХЭЛТЭС



# АЖ ҮЙЛДВЭР БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2022

## ТАНИЛЦУУЛГЫН АГУУЛГА

Оршил

- Танилцуулгын зорилго
- Танилцуулгын аргачлал

Аж үйлдвэр

- Уул уурхай олборлох салбар
- Боловсруулах аж үйлдвэр
- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж

Барилга

Харилцаа холбоо

Бүртгэлтэй аж ахуй нэгж

Дотоодын нийт бүтээгдэхүүн

- аж үйлдвэр, барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн

## 1. ТАНИЛЦУУЛГЫН ЗОРИЛГО:

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтээр нэгдсэн танилцуулга бэлтгэн, эдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлон, орон нутгийн удирдлага, бодлого хариуцсан ажилтнуудыг мэдээллээр хангах

## 2. ТАНИЛЦУУЛГЫН АРГАЧЛАЛ:

Статистикийн албан ёсны мэдээ тайланд тулгуурлан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, сүүлийн жилүүдээр харьцуулан дүгнэж, хүснэгт, графикаар өсөлт бууралтыг харуулж танилцуулгыг хийлээ.



### АЖ ҮЙЛДВЭР

#### 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Аймгийн хөгжлийн эхний 50 жил буюу социализмын үеийн хөгжлийн жилүүдэд олсон томоохон амжилтуудын нэг нь орчин үеийн аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөн явдал юм. Тус аймагт 1942 онд нийтийн хоол боловсруулах гуанз байгуулагдсанаар хүнсний болон аж үйлдвэрийн суурь тавигджээ. Улмаар энэ нь өргөжиж 1974 он гэхэд 4 тасагтай 50 гаруй ажилтантай болж, жилдээ 1.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6 сая төгрөгийн борлуулалт хийж байв. 1986 онд талх, нарийн боов, гоймон, архи, ундаа, сүү боловсруулж үйлдвэрлэх үндсэн 6 цехтэй шинэ үйлдвэр ашиглалтад орсон байна.

Үүнээс хойш 1949 онд аймгийн үйлдвэр хоршооллын артельд 1 мужаантай мод боловсруулах үйлдвэрийн суурь, 1948 онд гар ажиллагаатай хэвлэх үйлдвэр мөн 1961 оны 10 сарын 19-нд Эрдэнэдалай сумын нутаг Элэгний говийн нүүрсний ордод түшиглэн Цагаан овоогийн нүүрсний уурхайг 19 ажилтан, 5 гэр, 2 машинтай ашиглалтад оруулснаар уул уурхай, олборлох салбарын суурь тус тус тавигдсанаар Дундговь аймагт аж үйлдвэрийн салбар хөгжиж байсан байна. 1990 оны нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөр эдгээр үйлдвэрүүд хувьд шилжин ажиллаж байна.

#### 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


##### Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл

Манай аймагт аж үйлдвэрийн 4 салбарт үйл ажиллагаа явуулахаар 164 аж ахуй нэгж бүртгүүлснээс 41 нь буюу 25 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаагаас уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарт 5, боловсруулах салбарт 28, цахилгаан хий, уур агааржуулалтын салбарт 6, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 2 аж ахуй нэгж үйлдвэрлэл эрхэлж байна. Үүн дээр тус аймгийн газар нутагт уул уурхай,

олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хотын болон бусад аймгийн харьяа аж ахуй нэгж байгууллагуудыг хамруулан албан ёсны Статистик мэдээг цуглуулж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2022 онд /оны үнээр/ 25362.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 29482.4 сая төгрөгийн борлуулалт хийжээ. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 17.6 хувиар буюу 3788.5 сая төгрөгөөр өссөн байна. Дээрх өсөлтөд уул уурхай олборлох аж үйлдвэр 21.8 хувь, боловсруулах үйлдвэрлэл 21.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨСӨЛТИЙН ХУВЬ




ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар, сая.төг

Аж үйлдвэрийн салбар	2017	2018	2019	2020	2021	2022	22/21
Нийт дүн	8097.8	9330.3	10445.6	13080.9	21573.5	25362.0	117.6
Уул уурхай, олборлолт	3049.5	3648.3	4606.3	6746.5	14881.2	18120.4	121.8
Боловсруулах үйлдвэрлэл	1170.4	1225.8	1287.8	1308.4	1618.5	1970.4	121.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3200.4	3773.3	3787.0	4243.4	3266.2	3553.0	108.8
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	677.5	682.9	764.5	782.6	1807.5	1718.2	95.1

2022 оны аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын бүтцийг өмнөх онтой харьцуулбал уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбар 71.4 хувь болж, 2.4 нэгж хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбар 7.8 хувь болж, 0.3 нэгж хувиар тус тус өссөн бол цахилгаан хий, уур агааржуулалтын салбар 14.0 хувь болж, 1.1 нэгж хувиар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 6.8 хувь болж 1.6 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 2. ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, сүүлийн 3 жилээр, хувиар



### 1.1 УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР


Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 14 сумын нутагт давхардсан тоогоор 121, хайгуулын тусгай зөвшөөрөл 14 сумын нутагт 70, нийт 191 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 121 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагаас жонш-40, 25 нь нүүрс-25 /7 орд/, гөлтгөнө -19, барилгын материал-2, төмөр, цайр-8, 6 нь алт, шохойн чулуу-6, уран-3, бал чулуу-3, гантиг-2, мөнгө-2, перлит-1, холимог металл-1, литий-1, Цахиаур -1, Манган-1 байна. Хөрөнгө оруулалтын төрлөөр авч үзвэл дотоодын 84, хамтарсан 12, гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай 25 аж ахуй нэгж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг 70 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагаас дотоодын 55, хамтарсан 3, гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай 12 аж ахуйн нэгж байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2022 онд 18120.4 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 21.8 буюу 3239.2 сая төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг биет хэмжээгээр өмнөх онтой харьцуулахад нүүрс 7.3 хувиар, жонш 80.5 хувиар тус тус буурсан бол энэ онд 8.5 мянган тонн гөлтгөнө олборложээ.


ХҮСНЭГТ 2. УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021	2022	22/21
Нүүрс	мян.тн	15.3	15	12.8	22.1	233.8	216.7	92.7
Жонш	мян.тн	11.6	9.8	5.6	12.6	19.5	3.8	19.5
Гөлтгөнө	мян.тн	38.1	25.9	16.1	45.6	-	8.5	-

### 1.2 БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2022 онд 1970.4 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 21.7 хувиар өссөн байна. Тус салбарын энэхүү өсөлтөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 28.6 хувь, төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад эрдэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 59.5 хувь, үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл 28.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 4. БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр



ХҮСНЭГТ 3. БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр

	2021	2022	22/21 хувь
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ-НИЙТ	1618.6	1970.4	121.7
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1107.7	1424.1	128.6
Малын тэжээлийн үйлдвэрлэл	95.5	160.0	167.5
Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл	68.9	49.9	72.4
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	19.7	25.4	128.9
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	131.0	153.4	117.1
Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа	27.9	19.5	69.9
Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	90.0	13.9	15.4
Дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл	77.9	124.2	159.5

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад чихэр, бялуу, архи, ааруул, модон эдлэл үйлдвэрлэл өссөн бол хүснэгт маягт, талх, нарийн боов, цэвэр ус, хэрчсэн гурил, оёдол эсгүүр буурсан байна. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг сүүлийн 6 жилээр өсөлт бууралтыг хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 4. БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021	2022	2022/2021%
Хүснэгт маягт	м,х,д,х	272.9	320.1	334.2	347.3	398	347.4	87.3
Талх	тн	116.8	126.2	147	149.9	144.7	121.4	83.9
Нарийн боов	тн	115.4	111.5	122.9	133.3	157.1	141.1	89.8

Чихэр	тн	3.4	3.3	2.9	3.7	3	3.9	130.0
Бялуу	тн	1.1	2.1	2.3	1.2	3.2	6.3	196.9
Архи	мян.л	27.9	29.3	25.1	14.8	12.4	15.6	125.8
Ундаа	мян.л	1.7	8.6	0.2	0		0	-
Цэвэр ус	мян.л	15.4	24.1	50.3	12.1	7.5	1.3	17.3
Хэрчсэн гурил	тн	9.6	4.2	3.1	4.3	35.9	29.2	81.3
Хиамны зүйл	тн	0.4	0.8	0.5	1.3	0.3	0	0.0
Сүү/Тараг	мян.л	5.4	6	9.5	0.4	0	0	-
Хоормог	мян.л	0.7	0.5	0.8	0.3	0	0.2	-
Ааруул	тн	0.9	3.3	1.2	0.3	0.3	0.7	233.3
Оёдол эсгүүр	сая.төг	67.8	54.4	27.7	33.2	109.7	39.3	35.8
Модон эдлэл үйлдвэрлэл	сая.төг	102.6	151.6	125.5	221	131	153.4	117.1

Аймгийн боловсруулах бусад салбарын үйлдвэрлэлийн дийлэнх хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор тогтмол хэрэгжүүлдэг сангуудын мэдээллийг харвал “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан”-гаас 2016, 2017, 2018, 2021 онд тус аймагт зээл олгогдоогүй, Жижиг дунд үйлдвэрийн бодлогын сангаас 2017 онд 1 ААНБ 1 төсөл, 2018 онд 2 ААНБ 2 төсөлд нийт 900 сая төгрөгийн зээл авсан байна. 2019 онд тус аймагт “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” –аас 1 тэрбум төгрөг хуваарьлагдснаас үйлдвэрлэл эрхлэгчдэд 755.0 сая төгрөгийн зээл олгогдсон бөгөөд 2020 онд ЖДҮДС-аас 470 сая төгрөг, 2022 онд 220 сая төгрөгийн бага хувийн хүүтэй зээлийг үйлдвэрлэл эрхлэгчдэд олгосон юм.

Мөн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготой Хоршоо хөгжүүлэх сан сүүлийн жилүүдэд тогтмол зээл олгож байна. Хоршоог хөгжүүлэх сан 2022 онд аймгийн хэмжээнд 1008.3 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд 45 ажлын байр хадгалагдаж, 41 ажлын байр шинээр бий болсон байна.

#### ХҮСНЭГТ 5. 2022 ОНЫ СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сум	Ажлын байр		Олгогдсон зээл /сая төгрөг/	Үйл ажиллагааны чиглэл					
	Хадгалагдсан	Шинээр бий болсон		Хүнсний үйлдвэр	Хөнгөн үйлдвэр	Газар тариалан	Хөдөө аж ахуй	Үйлчилгээ	Бусад
Сайнцагаан	22	19	515.0	0	70	0	150	295	0
Адаацаг	3	2	72.0	37	0	0	0	35	0
Баянжаргалан	0	0	0	0	0	0	0	0	0
Говь-Угтаал	0	0	0	0	0	0	0	0	0
Гурвансайхан	2	2	20.0	0	0	20	0	0	0
Дэлгэрхангай	0	0	0	0	0	0	0	0	0
Дэлгэрцогт	0	0	0	0	0	0	0	0	0



Дэрэн	0	0	0	0	0	0	0	0	0
Луус	1	0	110.0	0	0	0	0	110	0
Өлзийт	2	5	50.0	0	0	0	50	0	0
Өндөршил	2	1	70.0	0	20	20	30	0	0
Сайхан-Овоо	9	12	92.3	0	27.30	0	50	15	0
Хулд	4	0	79.0	0	59	0		20	0
Цагаандэлгэр	0	0	0	0	0	0	0	0	0
Эрдэнэдалай	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	45	41	1008.3	37.0	176.3	40.0	280.0	475.0	0.0


Эх сурвалж: Хүнс хөдөө аж ахуйн газар

### 1.3 ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ

Дундговь аймгийн төв болон 14 сум бүхэлдээ төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд тус аймагт Багануур-Зүүн өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ий Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбар ажиллаж байна. Дулаан хангамжийн хувьд аймгийн төв Сайнцагаан сумын аж ахуйн нэгжүүд болон аймгийн айл өрхийн хэрэглэгчдэд Ган-Илч ХХК, Тэвшийн говь ХХК, Дундговь-Ус ОНӨУҮГ, Ариунболор ХХК, Есөн-Эрдэнэ эв констракш ХХК-ууд дулаан үйлдвэрлэн түгээж байна. Мөн аймгийн нийт 14 сум бүгд төвлөрсөн халаалтын системд холбогдоод байгаа бөгөөд үүнээс 6 суманд Ган-Илч компани дулаанаар ханган ажиллаж байна.

Цахилгаан, хий, уур агааржуулалтын салбар 2022 онд 3553.0 сая төгрөг болж өмнөх оноос 8.8 хувиар буюу 286.8 сая төгрөгөөр өссөн байна. Энэ салбарын гол бүтээгдэхүүн нь тус аймгийн хувьд дулаан үйлдвэрлэл бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар биет хэмжээ 127.8 мянган гкал болж, өнгөрсөн онтой харьцуулбал 17.1 хувиар өссөн байна /Зураг.5/

### ЗУРАГ 5. ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ



## 1.4 УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дундговь аймгийн төв болон 14 сумын нийт хүн амын цэвэр усны хэрэглээг газрын гүний усаар хангаж байна. Тус аймгийн усан хангамж болон цэвэр бохир усны хангамж ариутгалын салбарт Дундговь-Ус ОНӨҮГ дангаараа үйл ажиллагаагаа явуулж аймгийн иргэдийн хэрэгцээг ханган ажиллаж байна. Дундговь –Ус ОНӨҮГ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын хүн ам, албан газар, аж ахуйн нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн халдваргүйжүүлэх, нийтийн халуун усны ашиглалт, 2.1, 0.5 мв хүчин чадалтай нам даралтын зуухны ашиглалтыг хариуцаж дулаан үйлдвэрлэх түгээх үйлчилгээг холбогдох тусгай зөвшөөрлүүдийн дагуу хариуцан ажилладаг 100 хувийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 2022 онд 1 718.2 сая төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 4.9 хувиар буюу 89.3 сая төгрөгөөр буурсан байна.

### ХҮСНЭГТ 6. САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021	2022	2022/ 2021
Түгээсэн цэвэр ус	мян.м3	122.3	121.9	140.6	142.3	281.1	219.6	78.1
Сувагжуулалт	мян.м3	78.3	84.7	83.2	94.5	176.5	147.2	83.4
Зайлуулсан хог хаягдал	мян.тн				84.9	73.3	78.9	107.6


Салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг биет хэмжээгээр авч үзвэл түгээсэн цэвэр ус 21.9 хувиар, сувагжуулалт 16.6 хувиар тус тус буурсан бол зайлуулсан хог хаягдал 7.6 хувиар өссөн байна.



### 2. БАРИЛГА

Дундговь аймгийн хэмжээнд 2022 онд 38886.4 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 19.0 хувиар өссөн байна. Энэ онд 36907.8 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 1978.6 сая төгрөгийн их засварын ажил хийжээ. /Хүснэгт-7, Зураг 6 /

### ЗУРАГ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сая төгрөгөөр



2022 онд 10197.5 сая төгрөгийн орон сууцны барилга, 6300.0 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 185.3 сая төгрөгийн эмнэлгийн зориулалттай барилга, 862.0 сая төгрөгийн цэцэрлэгийн барилга, 160.0 сая төгрөгийн сургуулийн барилга, 5038.1 сая төгрөгийн соёлын салбарын барилга, 2350.0 сая төгрөгийн спорт биеийн тамирын барилга, 1940.0 сая төгрөгийн конторын барилга, 1990.0 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 1762.9 сая төгрөгийн эрчим хүчний барилга, байгууламж, 4175.0 сая төгрөгийн хатуу хучилттай зам, 1848.0 сая төгрөгийн далан, суваг шугам, 99.0 сая төгрөгийн бусад зам талбайн ажил хийгдсэн бол 1978.6 сая төгрөгийн барилгын их засварын ажлууд тус тус хийгдсэн байна.

ХҮСНЭГТ 7. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, сая төгрөг

Барилгын төрөл	2017	2018	2019	2020	2021	2022	22/21 хувь
Нийт	8003.6	9515	146165	25655.5	32664.8	38886.4	119.0
Орон сууцны барилга	1620	700	3485	465	7265	100.0	1.4
Орон сууцны барилга, үйлчилгээтэй					1020	0.0	-
Орон сууцны барилга, гарааштай			800	2680	964	10097.5	1047.5
Худалдаа, үйлчилгээний	1462.3	3330.5	678.3	1375.3	2691.8	6300.0	234.0
Эмнэлэг	300	1350	1872	5268	3017	185.3	6.1
Цэцэрлэг			3272.1	1333.5	0	862.0	-
Сургууль		1509.9	4062.5		1741.6	160.0	9.2
Соёлын			944.8	1142.3	2652.6	5038.1	189.9
Спорт, биеийн тамир		629	0	2205	0	2350.0	-
Конторын	80.3	85	3739	2147.4	1340	1940.0	144.8
Орон сууцны бус бусад барилга	459.7	1254.2	728.4	1302.2	1025.4	1990.0	194.1
Эрчим хүчний	44.9	97.5	125760		230	1762.90	766.5
Хатуу хучилттай авто зам	820.7	-	-	1958	242	4175.0	1725.2
Сайжруулсан хөрсөн зам	-	-	-	70	7647.2	0.0	0.0

Далан, суваг, шугам	164.3	15.7	0	4589.5	403.8	1848.0	457.7
Бусад (бусад зам, талбайн ажил)	268.3	-	124.4	367.8	0	99.0	-
Орон сууцны барилгын их засвар	169	543.2	-	282.7	986.7	264.1	26.8
Орон сууцны бус барилгын их засвар	2562.1	-	698	468.8	0	864.6	-
Инженерийн барилга байгууламжийн их засвар	52	-	-	-	0	849.9	-
Төмөр бетон гүүр, гүүрэн гарц					1437.7		-

2022 онд баригдаж дууссан томоохон бүтээн байгуулалтаас дурдвал аймгийн төвд Ахмадын өргөө, Ид шидийн орон Дундговь хүүхэд хөгжүүлэх төв, цэвэрлэх байгууламж, Эрдэнэдалай суманд цэвэрлэх байгууламж, Их газрын чулуу, Цагаан суваргад отоглох газар зэрэг байна.

### 3. ХАРИЛЦАА ХОЛБОО

**Харилцаа холбоо:** Дундговь аймгийн бүх сумд шилэн кабельд холбогдсон бөгөөд сумдууд шилэн кабель ашиглаж өндөр хурдаар интернетэд холбогддог. Мөн Юнител группын Юнивишн компани, Монголын Цахилгаан холбоо компани өрхийн интернетийн холбоос, телевизийн суваг, суурин утас гурвыг нэгтгэсэн гурвалсан үйлчилгээг үзүүлж байна. Үүрэн телефоны сүлжээний хувьд юнител, мобиком, жимобайл бүх сумдад, скайтелын сүлжээ 12 суманд /Сайхан-овоо, Өлзийт, Дэлгэрхангай сумдын сүлжээ ажиллахгүй байгаа/ сүлжээтэй, мобиком, юнител компаниуд бүх сумдад 4 жи технологи нэвтрүүлж хэрэглэгчиддээ өндөр хурдны интернет ашиглах боломжийг хангаж өгсөн байна. Мөн 2022 онд Юнител компани Өлзийт сумын Буянт баг, Эрдэнэдалай сумын Рашаант багуудад 4 жи сүлжээгээ өргөтгөсөн бол аймгийн төвийн Залуус хороололд 4 жи сүлжээг дэмжих станцыг байгуулсан байна.

#### ХҮСНЭГТ 8. ҮҮРЭН ТЕЛЕФОНЫ СҮЛЖЭЭ

Сумд	Мобиком	Скайтел	Юнител	Жи-Мобайл
Сайнцагаан	4жи	4жи	4жи	4жи
Адаацаг	4жи	3жи	4жи	3жи
Баянжаргалан	4жи	3жи	4жи	3жи
Говь-Угтаал	4жи	3жи	4жи	3жи
Гурвансайхан	4жи	3жи	4жи	3жи
Дэлгэрхангай	4жи	-	4жи	3жи
Дэлгэрцогт	4жи	3жи	4жи	3жи
Дэрэн	4жи	3жи	4жи	3жи
Луус	4жи	3жи	4жи	3жи
Өлзийт	4жи	-	4жи	3жи
Өндөршил	4жи	3жи	4жи	3жи
Сайхан-овоо	4жи	-	4жи	3жи
Хулд	4жи	3жи	4жи	3жи
Цагаандэлгэр	4жи	4жи	4жи	3жи
Эрдэнэдалай	4жи	3жи	4жи	3жи

Мэдээлэл харилцаа, холбооны салбарын орлого 2022 онд 7698.3 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 31.5 хувиар өссөн байна. Мэдээлэл, харилцаа, холбооны салбарын нийт орлогын 85.9 хувийг цахилгаан холбооны үйл ажиллагааны орлого эзэлж байна.

ЗУРАГ 7. ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, сая төгрөгөөр



2022 онд өмнөх онтой харьцуулахад харилцаа холбооны салбарын гол үзүүлэлтүүд бүгд өсөлттэй гарсан байна. Үүнд : Суурин телефон хэрэглэгчид 6.7 хувиар, үүрэн утасны идэвхтэй хэрэглэгч 5.5 хувиар, кабелийн телевизийн хэрэглэгчид 7.6 хувиар, нийт интернэт хэрэглэгчид 2.7 дахин тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 9. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021	2022	22 /21%
Нийт орлого	сая.төг	433.8	5 454.2	6 334.2	5 861.9	5 855.9	7698.3	131.5
Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааны орлого	сая.төг	-	404.5	699.8	466.8	513.8	1088.0	211.8
Цахилгаан холбооны үйл ажиллагааны орлого	сая.төг	-	5049.7	5634.4	5395.1	5342.2	6610.3	123.7
Суурин телефон цэг	тоо	518.0	723.0	751.0	870.0	981.0	1047.0	106.7
Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгч, (давхардсан тоогоор)	тоо	52872.0	55198.0	57167.0	53796.0	55771.0	58821.0	105.5
Кабелийн телевизийн хэрэглэгчид	тоо	1408.0	10315.0	11697.0	12530.0	13160.0	14157.0	107.6
MMDS/DTV/	тоо				222.0	244.0	279.0	114.3

АйПиТиВи /IPTV/	тоо				733.0	923.0	1335.0	144.6
Хиймэл дагуулаар	тоо				11575.0	11993.0	12543.0	104.6
Нийт интернэт хэрэглэгчид	мян.хүн	-	-	-	41.0	43.4	117.3	270.3



#### 4.БИЗНЕС РЕГИСТРИЙН САН.


Статистикийн бизнес регистрийн санд 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 1329 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 101-р буюу 8.2 хувиар өссөн байна. Үүнээс 221 төрийн бус байгууллага, 141 төсвийн байгууллага, 967 ААНБ байна. Нийт аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар хүснэгтэд харууллаа.

#### ХҮСНЭГТ 10. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, сумаар, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар

Сумд	Үйл ажиллагаа явуулж байгаа		Үйл ажиллагаа эхлээгүй		Үйл ажиллагаа түр зогсоосон		Үйл ажиллагаа бүрэн зогсоосон		Нийт	
	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
Бүгд	578	610	24	101	584	577	42	41	1228	1329
Сайнцагаан	304	325	8	50	356	350	16	15	684	740
Адаацаг	22	25	1	4	12	12	6	6	41	47
Баянжаргалан	19	19	4	5	24	25	1	1	48	50
Говь-Угтаал	14	16	0	3	13	13	1	1	28	33
Гурвансайхан	20	20	0	6	22	22	1	1	43	49
Дэлгэрхангай	18	19	1	3	13	12	0	0	32	34
Дэлгэрцогт	16	17	0	2	10	9	1	1	27	29
Дэрэн	16	16	1	1	6	7	1	1	24	25
Луус	19	19	2	4	16	16	1	1	38	40
Өлзийт	21	21	2	4	22	22	2	2	47	49
Өндөршил	16	16	0	3	25	25	5	5	46	49
Сайхан-Овоо	24	26	0	4	18	16	0	0	42	46
Хулд	26	27	1	2	23	25	1	1	51	55
Цагаандэлгэр	13	13	1	4	10	10	0	0	24	27
Эрдэнэдалай	30	31	3	6	14	13	6	6	53	56

Нийт ААНБ-ын 45.5 хувь нь буюу 610 ААНБ, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААНБ болон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа ААНБ-ын тоог сүүлийн жилүүдээр графикт харууллаа. /Зураг.8/

ЗУРАГ 8. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ААНБ, үүнээс үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг салбараар авч үзвэл 35.4 хувь буюу 216 нь бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

ХҮСНЭГТ 11. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН ТОО, эдийн засгийн салбараар

Салбар	2017	2018	2019	2020	2021	2022
Бүгд	639	663	706	679	578	610
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	23	21	15	15	12	11
Уул уурхай, олборлолт	8	10	9	4	6	5
Боловсруулах үйлдвэрлэл	36	38	40	35	28	28
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1	1	2	5	5	6
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4	4	3	3	2	2
Барилга	16	15	17	14	16	20
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклын засвар үйлчилгээ	197	209	224	217	199	216
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2	2	7	10	6	7
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	32	27	27	27	22	20
Мэдээлэл, холбоо	5	5	8	6	4	4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	25	25	27	26	17	17

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	5	4	5	5	4	3
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	41	50	54	53	51	56
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	14	13	14	13	13	14
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	49	49	49	49	49	50
Боловсрол	51	52	54	57	54	54
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	40	42	42	41	39	37
Урлаг, үзвэр, тоглоом наадам	22	22	23	26	19	19
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	68	74	86	73	32	41


## 5. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

ДНБ нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог бөгөөд Аймгийн ДНБ-ийг Монгол улсын Үндэсний Статистикийн хорооноос харьяатын зарчмыг баримтлан тооцож байна. Аймаг бүсийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон орлогын аргыг хослуулан тооцдог.

2022 оны аймгийн ДНБ оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 409.3 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 21.4 хувиар буюу 72.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд ХАА-н салбарын ДНБ өмнөх онтой харьцуулбал 27.6 хувиар, үйлдвэрлэлийн салбар 23.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Мөн үйлчилгээний салбарын ДНБ өмнөх онтой харьцуулахад 8.8 хувиар өссөн байна. /Зураг.10/




ЗУРАГ 9. ДНБ, зах зээлийн үнээр, тэрбум төгрөгөөр



Дундговь аймгийн ДНБ 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 409.3 тэрбум болж, Монгол улсын ДНБ-ий 0.8 хувийг, төвийн бүсийн ДНБ-ий 6.8 хувийг бүрдүүлж байна./Зураг.10/

ЗУРАГ 10. ТӨВИЙН БҮСИЙН ДНБ-ИЙ БҮТЭЦ, хувиар



Аймгийн ДНБ-ийг бусад төвийн бүсийн аймгуудтай харьцуулан сүүлийн 5 жилээр хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 12. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ДНБ, тэрбум төгрөгөөр

	2017	2018	2019	2020	2021	2022*	22/21%
Төвийн бүс	2865.4	3124.5	3677.5	4273.2	5046.7	5990.4	118.7
Говьсүмбэр	100.0	98.7	112.6	124.6	139.2	155.3	111.6

Дархан-Уул	414.9	420.9	524.2	661.5	766.3	714.4	93.2
Дорноговь	343.1	422.1	460.6	512.9	604.7	660.9	109.3
<b>Дундговь</b>	<b>266.8</b>	<b>316.5</b>	<b>372.6</b>	<b>348.6</b>	<b>337.0</b>	<b>409.3</b>	<b>121.4</b>
Өмнөговь	721.5	680.9	841.8	1054.3	1145.7	1904.4	166.2
Сэлэнгэ	558.4	653.5	739.9	867.5	1202.6	1220.7	101.5
Төв	460.9	531.8	625.8	703.8	851.2	925.4	108.7

2022 оны ДНБ-ий бүтцийг салбараар авч үзвэл ХАА-н салбар 59.2 хувь, үйлдвэрийн салбар 14.5 хувь, үйлчилгээний салбар 26.3 хувийг тус тус эзэлж байна. ДНБ-ий бүтцийг эдийн засгийн салбараар, сүүлийн 5 жилээр, бүтцээр хүснэгт 14-т харууллаа.

ХҮСНЭГТ 13. ДУНДГОВЬ АЙМГИЙН ДНБ-НИЙ БҮТЭЦ

Салбар	2017	2018	2019	2020	2021	2022*
ДНБ, зах зээлийн үнээр /тэрбум.төг/	266.8	316.5	372.6	348.6	337.0	409.3
Хөдөө аж ахуй	159.8	197.7	221.2	188.6	189.8	242.1
Үйлдвэрлэл	35.2	43.8	62.3	67	48.1	59.4
Үйлчилгээ	71.8	75	89.1	92.9	99.1	107.8
Аймгийн ДНБ-ий бүтэц, хувиар						
Бүгд	100	100	100	100	100	100
Хөдөө аж ахуй	59.9	62.5	59.4	54.1	56.3	59.2
Үйлдвэрлэл	13.2	13.8	16.7	19.2	14.3	14.5
Үйлчилгээ	26.9	23.7	23.9	26.7	29.4	26.3


2022\*- 2022 оны ДНБ-ийг урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон болно.

2022 оны аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 8639.4 мянган төгрөг болж, өмнөх онтой харьцуулбал 21.5 хувиар өссөн байна./Зураг.12/

ХҮСНЭГТ 14. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, 2017-2022 онуудаар, мянган төгрөгөөр

Нэг хүнд ногдох ДНБ	2017	2018	2019	2020	2021	2022*	22/21 хувь
Улсын дүн	9042.5	10314.1	11855.6	11612.9	13267.9	15826.4	119.3
Төвийн бүс	5761.1	6161.1	7227.0	8385.0	9785.6	11575.1	118.3
Дундговь	5805.7	6792.3	7968.7	7418.4	7108.9	8639.4	121.5

ЗУРАГ 11. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, мянган төгрөгөөр



2022\*- 2022 оны ДНБ-ийг урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон болно.

Ашигласан ном материал

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл 2017-2021
2. Аймгийн нийгэм эдийн засгийн танинцуулга 2017-2021
3. Дундговь аймгийн товч түүх 1991 он
4. Аймгийн Бизнес регистрийн сан 2012-2021
5. www.nso.mn
6. www.1212.mn

Мэдээлэл авах холбоосууд:

<http://www.dundgovi.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн  
дарга Б.Энхтуяа  
Утас: (976)-70593777

Дундговь аймгийн статистикийн хэлтсийн  
Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн  
Утас: (976)-70593715, 88057913  
Byambasuren@nso.mn

ХАЯГ: ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 319, 320 ТООТ



Dundgovi@nso.mn



70593715